

Бид шашны болон ухамсрын эрх чөлөөнд итгэдэг

Дараах асуултуудад хариул.

- Та хэзээ өөрөөсөө өөр итгэл үнэмшилтэй хүнтэй шашин болон сүнслэг итгэл үнэмшлийн талаар ярилцсан бэ?
- Тэд таны итгэл үнэмшилд хэрхэн хандсан бэ? Та тэдний итгэл үнэмшилд хэрхэн хандсан бэ?

Дараах жишээг эргэцүүлэн бод.

Лиам бол сургуулийнхаа хөлбөмбөгийн багийн гишүүн юм. Түүний багийн нэг гишүүн Заин тоглолт бүрийн өмнө хувийн шашны зан үйл үйлддэг. Заин багийнхан дотроо ганцаараа энэ шашныг шүтдэг. Багийн бусад гишүүн Заины юу хийдгийг анзаараад, энэ тал дээр түүнд хүндрэл учруулж эхлэв. Лиам эргэн тойрных нь хүмүүс Заины шашныг заримдаа сөрөг байдлаар хардаг гэдгийг мэддэг.

Дараах материалуудыг судалж, тэдгээрийг Лиамын нөхцөл байдалд болон та нараас өөр итгэл үнэмшилтэй хүмүүстэй харилцах харилцаандаа хэрхэн ашиглаж болохыг бодож үзээрэй.

Алма 30:7–9

Итгэлийн тунхаг 1:11

Бошиглогч Иосеф Смит (1805–1844) ийн заасан.



Хэрэв би аль нэг “Мормоны” төлөө амь насаа зориулахад бэлэн байдаг нь харуулагдсан бол, пресбитриен, баптист эсвэл бусад шашны аль нэг сайн хүн эрхээ хамгаалахын төлөө амь насаа зориулахад бас бэлэн; хожмын үеийн гэгээнтнүүдийн эрхийг улан доороо дэвсэлж байгаа шиг, . . . нэрд гараагүй бөгөөд өөрсдийгөө хамгаалахад хүчин мөхөс аливаа бусад шашны эрхийг улан доороо дэвсэлж байгааг эсэргүүцэн, миний бие амь насаа өргөхөд бэлэн байна гэдгийг Тэнгэрийн өмнө зоригтой тунхаглаж байна.

Бие сэтгэлд минь сүнслэгээр нөлөөлдөг зүйл бол эрх чөлөөг хайрлах хайр—бүх хүн төрөлхтний иргэний болон шүтлэг бишрэлийн эрх чөлөө юм. (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит [2007], 390*)

- Тулгараад байгаа тухайн нөхцөл байдалд хариулахад туслах юуг та Лиамтай хуваалцаж чадах вэ?
- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр таныг өөр итгэл үнэмшилтэй хүмүүст хэрхэн хандаасай гэж хүсдэг талаар та юу сурч мэдсэн бэ?